



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/459

Булган сум

**Автотээврийн салбар үүсэж хөгжсөний
100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2 дугаар хавсралтын 1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярыг Булган аймагт 2025 оны 07 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Түүхэн тэгш ойг тэмдэглэхэд зориулан 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

